

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3. Менежментийн захидал.....	11
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан	15
4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	15
4.2. Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	16
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	17
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	19
4.5. Зорилтот түвшин, түүний гүйцэтгэл.....	20
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НХАЗ	Нэг худалдан авагчийн загвар
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТТЗЭ	Түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигчид
ҮТЗЭ	Үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчид
ХУД	Хан-Уул дүүрэг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Г.БАЛЖИННЯМ ТАНАА

2020.03.13 № 06/792
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Диспетчерийн үндэсний төв ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Диспетчерийн үндэсний төв ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Диспетчерийн үндэсний төв ХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал


- Албан ёсны шийдвэргүйгээр ажиллагсдад урамшуулал олгож 312.4 сая төгрөгийн цалингийн өглөг үүсгэсэн;
 - Ашиглалтад байгаа 25.4 сая төгрөгийн хангамжийн материалыг зардалд шууд тусгасан;
 - Татварын болон нийгмийн даатгалын байгууллагатай хийх тооцоог 76.3 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан
- зэрэг нь эрх ба үүрэг, иж бүрэн байх, тохиолдсон байх, тодруулга ба толилуулга, үнэн зөв батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Диспетчерийн үндэсний төв ХХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТЫН ТАЙЛАН

2.1. ОРШИЛ

Диспетчерийн үндэсний төв ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Диспетчерийн үндэсний төв ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Балжинням Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн цаашид анхан шатны баримтын бүрдлийг хангах, авлага өглөгийг баталгаажуулж байх, хөрөнгийн ашиглалт хамгаалалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, зорилтот түвшинд заасан зардлын хэмжээг хэтрүүлэн зарцуулахгүй байх, байгууллагын дотоод хяналтыг сайжруулах талаар Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО, ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Диспетчерийн үндэсний төв ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Диспетчерийн үндэсний төв ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн өмчит байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Диспетчерийн үндэсний төв ХХК-ийн удирдлага тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС, түүнд нийцүүлэн баталсан Сангийн сайдын журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль, стандарт болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 12 дугаар сарын 02-ноос 2020 оны 03 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Баян суварга Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Диспетчерийн үндэсний төв ХХК 2019 оны санхүүгийн тайланг “Баян суварга Аудит” ХХК-д 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 01/163 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. АУДИТАД МӨРДСӨН БОДЛОГО, ЖУРАМ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Диспетчерийн үндэсний төв ХХК-ийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Оновчтой зохицуулалт, чанартай эрчим хүчийг үндэсний хэмжээнд” оршино.

Диспетчерийн үндэсний төв ХХК-ийн үйл ажиллагааны чиглэл нь:

- Цахилгаан, дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх үйл ажиллагааг хамгийн бага өртгийн шалгуурт нийцүүлэн диспетчерийн шуурхай удирдлага, зохицуулалтаар хангах,
- Цахилгаан дамжуулах гол шугам, холбогдох барилга байгууламжийн технологи, техник эдийн засгийн үндэслэл, барилгын төсөв
- Цахилгаан эрчим хүчний экспорт, импортын зохицуулалт хийх
- Нэгдсэн сүлжээний горим тооцоо, реле хамгаалалт, автомат шуурхай удирдлага, холбоо мэдээллийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх
- Нэгдсэн сүлжээний арилжааны үйл ажиллагааг удирдан явуулах ажлыг зохион байгуулж, эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх загварыг боловсронгуй болгох.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Диспетчерийн үндэсний төв ХХК санхүү нягтлан бодох бүртгэлийн “unicus” программ, мөн “Нэг худалдан авагчтай загвар”-ын тайлан бүртгэлд “sbm.energy.mn” программ хангамж ашигладаг байна.

Диспетчерийн үндэсний төв ХХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд үр нөлөөтэй гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Диспетчерийн үндэсний төв ХХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 13 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 730,453.6 сая төгрөгөөс тооцон 14,609.1 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 222.9 сая төгрөгөөр тогтоосон нь компанийн 2019 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогоос тооцсонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Диспетчерийн үндэсний төв ХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11,766.2 сая төгрөгөөр буюу 21.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж төлсөн зардал данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3,718.7	6,861.5	3,142.8
Авлага	39,350.3	46,321.5	6,971.2
Бараа материал	258.3	200.5	(57.8)
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	1,593.1	1,593.1
Үндсэн хөрөнгө	8,749.7	8,945.0	195.3
Биет бус хөрөнгө	3,566.3	3,487.9	(78.4)
Нийт хөрөнгө	55,643.3	67,409.5	11,766.2
Өр төлбөр	52,286.1	72,863.7	20,577.6
Эздийн өмч	3,357.2	(5,454.2)	(8,811.4)
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	55,643.3	67,409.5	11,766.2

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл оны эхнээс 3,142.8 мянган төгрөг буюу 84.5 хувиар өссөн нь компанийн үйл ажиллагаатай холбоотой мөнгөн хөрөнгө 1,611.9 сая төгрөгөөр, импортын тооцоотой холбоотой мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1,531.0 төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой байна.

Авлага данс өмнөх оноос 6,971.2 сая төгрөгөөр өсөж, нийт 46,321.5 сая төгрөг болсон, үүнд компанийн өөрийн үйл ажиллагаатай холбоотой 736.7 сая төгрөг, нэг худалдан авагчийн загварын тооцооны үлдэгдлийн 45,584.8 сая төгрөгийн авлагыг тус тус бүртгэсэн байна.

Нэг худалдан авагчийн загварын тооцооны үлдэгдлийн 45,584.8 сая төгрөгийн авлагын үлдэгдэлд дараах авлагыг бүртгэж тайлагнасан байна. Үүнд:

- Дансны авлагад 19 ААН, байгууллагатай холбоотой 38,646.0 сая төгрөг,
- Бусад авлагад “Баруун бүс ЭХС” ХК -аас авах 4,900.0 сая төгрөг,
- НӨАТ-ын авлага 1,467.4 сая төгрөг,
- Хэрэгжээгүй НӨАТ /импорт/-ийн авлага 476.3 сая төгрөг
- Экспорт, импортын авлагад 8 ААН, байгууллагатай холбоотой 95.1 сая төгрөгийн авлага бүртгэгдэж байна.

Нэг худалдан авагчийн томоохон авлагатай, орлого дутуу төвлөрүүлсэн “УБЦТС” ТӨХК-с 20,148.6 сая, “Титан грид” ХК-с 1,082.2 сая, Улаанбаатар сүлжээ ХХК-с 785.7 сая, Даланзадгад ДЦС-аас 229.8 сая төгрөгийн авлага бүхий байгууллагууд байна.

“Баруун бүс ЭХС” ХК -аас авах 4,900.0 сая төгрөг нь Монгол улсын Засгийн газрын 2019 оны 287 дугаар тогтоол, Эрчим хүчий сайдын 2019 оны 193 дугаар тушаалаар УБЦТС ТӨХК-ийн Нэг худалдан авагчийн дансанд төвлөрүүлж үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд хуваарилагдах ёстой байсан агаарын бохирдлын төлбөр болох 4,900.0 сая төгрөгийг Нэг худалдан авагчийн дансаар дамжуулахгүйгээр ДҮТ ХХК-ийн импортын дансанд шилжүүлэн

шууд ОХУ-д Баруун бүсийн эрчим хүчний системийн төлбөрийг төлсөнтэй холбоотойгоор үүссэн авлага байна.

Авлагын үлдэгдлийг насжилтаар нь авч үзвэл 3-5 жилийн насжилттай 25,853.4 сая төгрөг, 1-3 жилийн 14,852.3 сая төгрөг, 1 жилийн насжилттай 4,879.1 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 57.8 сая төгрөгөөр буурсан нь сэлбэг хэрэгсэл, хангамжийн материалыг өмнөх оны нөөц үлдэгдлээс зарцуулсантай холбоотой байна.

Тайлант онд 1,593.1 сая төгрөгийн урьдчилж төлсөн зардлын үлдэгдэлд тус компанийн 2019 оны төлөвлөгөөнд тусгагдсан барилгын их засварын ажлыг 2,179.4 сая төгрөгөөр гүйцэтгэхээр “Их даян бүүвэй” ХХК-тай байгуулсан гэрээний урьдчилгаа төлбөрийн 1,592.1 сая төгрөг, Магнай Трейд ХХК-д төлсөн шатахууны картын үлдэгдэл 1.0 сая төгрөгийг бүртгэсэн байна.

“Их даян бүүвэй” ХХК-тай гэрээ байгуулсан гэрээ дүгнэж үлдэгдэл төлбөрийн тооцоог хийсний эцэст үндсэн хөрөнгийн данс руу шилжүүлж, барилгын өртгийг капиталжуулахаар шийдвэрлэсэн байна.

Үндсэн хөрөнгө /үлдэгдэл өртгөөр/ 195.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд 1,113.8 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, ТӨБЗГ-ын 2019 оны А-1/3442 дугаар албан бичгээр элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 73.2 сая төгрөгийн хөрөнгийг ашиглалтаас хасаж, 49.6 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлсэнтэй холбоотой байна.

Биет бус хөрөнгөд VMWare программ хангамжийн лиценз 42.9 сая төгрөг, Colasoft Carpa программын лиценз 3.3 сая төгрөг, WAMS-ын программ хангамж 1,061.8 сая төгрөг, нийт 1,115.2 сая төгрөгөөр бүртгэгдэж байгаа бөгөөд тайлант хугацаанд 1,193.7 сая төгрөгийн элэгдэл байгуулж, үлдэгдэл өртгөөрөө өмнөх оноос 78.4 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Богино хугацаат өр төлбөрт компанийн үйл ажиллагаатай холбоотой 649.0 сая төгрөг, НХАЗ-ын 57,658.1 сая төгрөг, импортын тооцооны 4,849.7 сая төгрөгийн өглөгийг тус тус бүртгэж тайлагнасан байна.

Өглөгийн үлдэгдлийг насжилтаар нь авч үзвэл 3-5 жилийн насжилттай 41,088.6 сая төгрөг, 1 жилийн насжилттай 22,068.2 сая төгрөгийн өглөг бүртгэгдэж байна.

Урт хугацаат өр төлбөрт Германы Сэргээн босголтын банк болон Сангийн яамны дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу байгуулсан “Эрчим хүчний салбарын хөтөлбөр-1” төслийн зээлийн 8,120.8 сая төгрөг, улсын төсвийн хөрөнгө оруулалт, буцалтгүй тусламжаар авсан хөрөнгийн хойшлогдсон орлогоор хүлээн зөвшөөрөх 1,586.1 сая төгрөгийг тус тус бүртгэж тайлагнасан бөгөөд тайлант онд төслийн зээлийн 597.7 сая төгрөгийн үндсэн зээлийг төлж, хойшлогдсон орлогод бүртгэлтэй хөрөнгийн элэгдлийн зардлын 414.3 сая төгрөг, залруулгын гүйлгээний бичилтийн 477.3 сая төгрөгөөр тус тус өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

Дансны өглөг 21,887.0 сая төгрөгөөр өссөн ба үүнд импортын өглөг 68.2 сая төгрөгөөр буурсан хэдий ч компанийн үйл ажиллагааны өглөг 172.7 сая төгрөгөөр өссөн, НХАЗ-ын өглөг 21,782.4 сая төгрөгөөр өссөн байна. Компанийн үйл ажиллагааны өглөгт диспетчерийн зохицуулалтын илүү төлбөр 30.7 сая төгрөг, харилцагч байгууллагуудад төлөх 144.5 сая төгрөг байна.

Татварын өр нийт дүнгээр 628.2 сая төгрөгөөр өссөн бөгөөд үүнд компанийн үйл ажиллагаанаас үүссэн өр төлбөр 36.3 сая төгрөгөөр буурсан хэдий ч импортын гаалийн татварын тооцоо 664.5 сая төгрөгөөр өссөн нь нөлөөлж байна.

Бусад богино хугацаат өр төлбөр 485.7 сая төгрөгөөр буурсан ба импортын тооцооны богино хугацаат өр төлбөр 885.0 сая төгрөгөөр буурсан хэдий ч компанийн үйл ажиллагаатай холбоотойгоор 399.3 сая төгрөгийн өр төлбөр үүссэн нь ажилтнуудын жилийн үр дүнгийн ажилтнуудад олгох 312.4 сая төгрөгийн өр, баталгааны барьцаа 114.1 сая төгрөг байгаа болно.

Урт хугацаат зээл 597.7 сая төгрөгөөр буурсан нь Сангийн яамтай байгуулсан “Эрчим хүчний салбарын хөтөлбөр-1” төслийн зээлийн гэрээний тайлант хугацааны 597.7 сая төгрөгийн үндсэн зээлийг төлсөнтэй холбоотой байна.

Бусад урт хугацаат зээл 1,586.1 сая төгрөг ба оны эхнээс 892.9 сая төгрөгөөр буурсан нь УТХОБТ-аар авсан хөрөнгийн элэгдлийн зардлын 414.3 сая төгрөг, залруулгын гүйлгээний 477.3 сая төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл оны эхнээс 477.3 сая төгрөгөөр өсч 587.8 сая төгрөгөөр тайлагнагдсан нь буцалтгүй тусламжаар авсан хөрөнгийн дахин үнэлгээний бууралтыг тус дансанд бүртгэсэн байсныг залруулсантай холбоотой байна.

Тайлант үеийн алдагдал 8,746.7 сая төгрөг (үүнээс компанийн үйл ажиллагаанаас үүссэн бодит бус ашиг 3,317.4 сая төгрөг, НХАЗ-ын алдагдал 11,940.2 сая төгрөг, импортын үйл ажиллагаанаас үүссэн алдагдал 123.9 сая төгрөг)-өөр тайлагнагдсан байна.

2.9. Зорилтот түвшин түүний гүйцэтгэл

Диспетчерийн үндэсний төв ХХК-ийн 2019 оны үйл ажиллагааны үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг Эрчим хүчний сайдын 2019 оны 12 дугаар баталсан ба 189 дугаар тушаалаар тодотгосон, компанийн 2019 оны бизнес болон зардлын төлөвлөгөөг ТУЗ-ийн 2019 оны 03, 17 дугаар тогтоолоор тус тус баталсан байна.

Зорилтот түвшний төлөвлөгөөгөөр 2019 онд 10,347.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж 10,289.0 сая төгрөг зарцуулж 58.9 сая төгрөгийн татвар төлөхийн өмнөх ашигтай ажиллагааар төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 10,728.9 сая төгрөгийн орлого олж, 7,411.5 сая төгрөг зарцуулж, 3,317.4 сая төгрөгийн татвар төлөхийн өмнөх ашигтай ажилласан байна.

Тус компани “Нэг худалдан авагч (НХА)-тай загвар”-ын хүрээнд нийт 15 үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчид /ҮТЗЭ/-ээс цахилгаан эрчим хүч худалдан авч, нийт 22 Түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигчид /ТТЗЭ/-д цахилгаан эрчим хүч худалдан борлуулж төлбөр тооцоог хийдэг байна. Тайлант онд Нэг худалдан авагчтай загварын тайлангаар нийт 739,038.9 сая төгрөгийн орлого олж, 855,753.9 сая төгрөгийн зардал гаргаж, 16,715.0 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Тус компани нь диспетчерийн зохицуулалтаас 10,124.8 сая төгрөг, бусад үйл ажиллагааны орлогоос 223.1 сая төгрөг, нийт 10,347.9 сая төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэй байснаас гүйцэтгэлээр диспетчерийн зохицуулалтаар 10,124.8 сая төгрөг, үндсэн бус үйл ажиллагаанаас 1,018.4 сая төгрөг, нийт 11,143.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, орлогын төлөвлөгөөг 795.4 сая төгрөгөөр давахад нөлөөлжээ.

Компанийн 2019 оны зардлын тодотгосон төлөвлөгөөг ТУЗ-ийн 17 дугаар тогтоол, Эрчим хүчний сайдын 189 дүгээр тушаалаар 10,585.1 сая төгрөг байхаар батлуулсан ба санхүүжилтийн эх үүсвэр нь зөвшөөрөгдсөн дүнгээр зардлын төлөвлөгөө 10,289.0 сая төгрөг байхаас гүйцэтгэлээр 7,825.6 сая төгрөг болж, төлөвлөгөөнөөс 2,463.1 сая төгрөг буюу 23.9 хувийн хэмнэлт үүссэн байна. Үүнд:

Борлуулсан бүтээгдэхүүний өртөг 2,797.8 сая, борлуулалт маркетингийн зардлыг 5.9 сая, ерөнхий ба удирдлагын зардлыг 57.0 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан, бусад зардалд 136.9 сая төгрөг төлөвлөснөөс 529.2 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа нь үндсэн бус үйл ажиллагааны орлого нэмэгдсэнтэй холбоотой байна.

Борлуулсан бүтээгдэхүүний өртгийн 2,797.8 сая төгрөгийн хэмнэлт нь барилгын их засвар болон өргөн хүрээт хяналтын (WAMS) системийг Монгол улсын эрчим хүчний системд нэвтрүүлэх төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлын бүтээгдэхүүний өртөгт шингэх хэсэг ба энэ нь гүйцэтгэлээр үндсэн хөрөнгөд бүртгэгдсэн. Хөрөнгийг олж бэлтгэх зардлын санхүүжилтийн эх үүсвэрийг ЭХЗХ-оос батлахдаа тус компанийн диспетчерийн зохицуулалтын орлого буюу тарифаар хүлээн зөвшөөрч баталсантай холбоотойгоор тус хөрөнгийг зардалд тусган батлуулах шаардлага үүссэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 13 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 3 эрсдэл тодорхойлж нийт 17 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 528.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 112.8 сая төгрөгийн алдааг залруулж, 1 албан шаардлага хүргүүлж, 415.3 төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өглөө.

- Завсрын аудитаар илэрсэн зохицуулах үйлчилгээний орлогын дутуу төлбөрийн 45.2 сая төгрөг, нийгмийн даатгалын байгууллагаас авах хөдөлмөрийн чадвар алдсаны болон жирэмсний амаржсаны тэтгэмжийн дансны бичилтийг буруу хийсэн 28.6 сая төгрөг, ХХОАТ-ын тайланд татвар төлөгчийн нэрийг буруу бичсэн 25.0 сая төгрөг, касст байх мөнгөний дээд хязгаарыг зөрчсөн 14.0 сая төгрөгийн алдаа зөрчлийг тус тус залрууллаа.

- Компанийн шуурхай ажиллагааны зориулалтаар 2018 онд худалдан авсан туулах чадвар сайтай Ланд-TLC200 маркийн автомашиныг тус компанийн гүйцэтгэх захирал хот дотор зориулалт бусаар ашиглаж, шатахууны үргүй зардал гаргаж байгааг таслан зогсоож, цаашид албан ажлын болон тусгай зориулалтын автомашины ашиглалтад тавих хяналтыг сайжруулж ажиллахыг өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж болгосныг хэрэгжүүлээгүй, зөрчлийг дахин давтан гаргасан байна. Энэ нь санхүүгийн тайлагналын “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг зөрчиж байгаагаас гадна “Суудлын автомашины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолын 1, 2, 4 дүгээр заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Аудитаар илэрсэн 415.3 сая төгрөгийн алдаа, зөрчилд 6 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар Диспетчерийн үндэсний төв ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, татварын тооцооны зөрүүг хэрхэн шийдвэрлэснийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Диспетчерийн үндэсний төв ХХК Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 7 төрлийн 200 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлж, 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй буюу зөвлөмжийн хэрэгжилт 66.7 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Диспетчерийн үндэсний төв ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хязгаарлалттай” дүгнэлт

Диспетчерийн үндэсний төв ХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй 415.3 сая төгрөгийн зөрчил нь бидний тооцсон 222.9 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс их байгаа тул хязгаарлалттай дүгнэлтийг өгч байна.

Диспетчерийн үндэсний төв ХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөөг эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг СТОУС-ын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Диспетчерийн үндэсний төв ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

3.1.1. Илрүүлэлт:

Кассаас дараа тайлангаар зарцуулж байгаа арга хэмжээний зардлын төсвийг зардлын зүйл бүрээр нарийвчлан хянаж баталдаггүй, гүйцэтгэлийг батлагдсан маягт, төсвийн дагуу тайлагнадаггүй, анхан шатны бүрдэл дутуу баримтаар 5.0 сая төгрөгийн гүйлгээг бүртгэж тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4-д "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.1.2. Эрсдэл:

Мөнгөн хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт суларч, ашиглал, шамшигдал үүсэх.

3.1.3. Өгсөн зөвлөмж:

Мөнгөн урьдчилгааны тайланг Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан маягтаар хөтлөж, анхан шатны баримтын бүрдлийг хангуулж, мөнгөн хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2. Авлага, өр төлбөрийн данстай холбоотой асуудал

3.2.1. Илрүүлэлт:

Татварын болон нийгмийн даатгалын байгууллагатай хийх тооцоог 72.6 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнасан нь санхүүгийн тайлагналын “толилуулга ба илчлэл”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг зөрчиж байгаагаас гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулж ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Санхүүгийн тайланд авлага, өр төлбөрийн дүн буруу илэрхийлэгдсэнээр санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд буруу ташаа мэдээлэл өгөх.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Тайлант оны эцэст татвар, нийгмийн даатгал, ААНБ хоорондын авлага, өр төлбөрийн тооцоог бүрэн нийлж баталгаажуулан тайлан тооцоонд бүртгэлээр тавих дотоод хяналтыг сайжруулах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.3. Хөрөнгийн данстай холбоотой асуудал

3.3.1. Илрүүлэлт:

